

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Орхон АЗЗА” ТӨХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ОРА-2025/003/НА-СТА-ТӨҮГ

Цахим хуудас:
www.audit.mn

Орхон аймаг
2025 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: П.Пүрэвлхагва
Утас: 70353088 Цахим хаяг: ppurevlkhagva@gmail.com

Аудитын менежер: Б.Буян-Ундрах
Утас: 70355805 Цахим хаяг: buyanundrakhb@audit.gov.mn

Аудитор: “Төгс нотолгоо аудит” ХХК-ийн Ахлах аудитор:
Г.Цэцэгмаа
Утас: 99889665 Цахим хаяг: tugsnotolgooaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ТОС \o "1-3" \h \z \u 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН 6

HYPERLINK \l "_Тос193305350" 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА
..... **Error! Bookmark not defined.**

HYPERLINK \l "_Тос193305355" 4. АУДИТЫН ТАЙЛАН **Error! Bookmark not defined.**

4.1 Ерөнхий зүйл **Error! Bookmark not defined.**

4.2 Материаллаг байдал..... **Error! Bookmark not defined.**

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт **Error! Bookmark not defined.**

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт **Error! Bookmark not defined.**

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал **Error! Bookmark not defined.**

HYPERLINK \l "_Тос193305361" 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ **Error! Bookmark not defined.**

5.1 Төлбөрийн акт..... 9

5.2 Албан шаардлага 10

5.3 Зөвлөмж 10

HYPERLINK \l "_Тос193305365" 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ
ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ **Error! Bookmark not defined.**

Товчилсон үгийн жагсаалт

ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
АЗЗА	Авто замын засвар арчлалт
АТБӨЯХАТ	Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар
ААНОАТ	Аж ахуйн нэгжийн албан татвар
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2025.03.14 № 91
танай _____-ны № _____-г

“ОРХОН АЗЗА” ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
С.ГАНДОЛГОР ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Орхон АЗЗА” ТӨХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, эмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол “Орхон АЗЗА” ТӨХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлангийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

- Тайлант онд ерөнхий инженерийг туршлага судлуулах чиглэлээр 9,796.5 мянган төгрөгийн томилолтын зардал олгож, тухайн сард байгууллагын албан хаагчдад цалингийн урьдчилгаа олгоогүй, ажилтан ажлаас гарч байгууллагын хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан.
- Албан томилолтын хуудас, удирдамж, тайлангүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу 21,878.5 төгрөгийг томилолтын зардалд зарцуулсан.
- Тайлант хугацаанд 66,874.0 мянган төгрөгийн анхан шатны баримтын бүрдэл, дутуу гүйлгээ хийсэн, улсын бүртгэлийн гэрчилгээнд заасан үйл ажиллагааны чиглэл хамаарахгүй аж ахуйн нэгжээс 11,000.0 мянган төгрөгийн ажил үйлчилгээ авсан.

- Үндэслэлгүйгээр 1,620.0 мянган төгрөгийг түлээ нүүрсний хөнгөлөлтийг нийтийн орон сууцанд амьдардаг ажиллагсдад олгосон.
- Хээрийн нэмэгдэл хөлснөөс тооцох 3,438.0 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг нийгмийн даатгалын тайланд тайлагнаагүй.
- Ерөнхий нягтлан бодогч, тооцооны нягтлан бодогч, бичиг хэрэг хүний нооцийн ажилтан нар ажил үүргийн хуваарьт багтаагүй ажил гүйцэтгэсэн гэх шалтгаанаар 817.7 мянган төгрөгийн илүү цагийн нэмэгдэл цалин олгосон.
- Албан хаагчдад 258.0 мянган төгрөгийн хоол унааны нэмэгдлийг томилолтын зардалтай давхардуулан олгосон
- Тайлант онд зорилтот түвшний төлөвлөгөөгөөр 317.6 мянган төгрөгийн балансын ашигтай ажиллахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 328,431.9 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Дээрх зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтыг аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага хэрэгжүүлнэ", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20.1.4-д "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх", Нийгмийн даатгалын тухай хуулийн 19.1-д "Даатгуулагч, ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл ногдох орлогын бүрэлдэхүүнд дараах цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг хамааруулна.", 19.1.3-д "ажил олгогчоос даатгуулагчид мөнгөн хэлбэрээр олгосон хоол, унаа, түлээ, нүүрсний үнийн хөнгөлөлт, орон сууцны ашиглалтын төлбөр, тэдгээртэй адилтгах бусад орлого, сар, улирал, жилийн ажлын үр дүнг харгалзан олгосон шагнал, урамшуулал.", Компанийн тухай хуулийн 84.4-д "Компанийн эрх бүхий албан тушаалтан нь дараах үүрэгтэй: 84.4.3-д "компанийн эрх ашигт нийцүүлэн үндэслэлтэй шийдвэр гаргах.", 84.6-д "Компанийн эрх бүхий албан тушаалтан нь энэ хуулийн 84.4, 84.5-д заасан үүргээ биелүүлээгүй, удаа дараа зөрчсөнөөс компанид хохирол учруулсан бол учруулсан хохирлыг өөрийн хөрөнгөөр нөхөн төлнө.", гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2024 оны 10 дугаар сарын 16-ны 481 дүгээр тогтоолоор 33 нэр төрлийн үндсэн хөрөнгийн дахин үнэлгээг хийж, 182,052.0 мянган төгрөгийн дахин үнэлгээний нэмэгдлийг бүртгэж, тайлагнасан байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд ниит орлогыг 2,213,000.0 мянган төгрөгөөр, ниит зардлыг 2,212,647.4 мянган төгрөгөөр, 317.3 мянган төгрөгийн цэвэр ашигтай ажиллахаар тогтоосон байна.

Гүйцэтгэлээр 2,059,930.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 2,388,362.8 мянган төгрөгийн зардал гаргаж, 328,431.9 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Бусад асуудлын хэсэг

Тухай аудитыг хийх явцад аудитын дүгнэлт, тайлантай холбогдуулан аудит гүйцэтгэж буй төрийн аудитын албан хаагчид аливаа этгээдийн нөлөөлөл, мэдээллийн нууцлал, ёс зүйтэй холбоотой холбогдох хуулийн дагуу мэдэгдлүүдийг гарган баталгаажуулсан болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлангийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

The image shows a handwritten signature in black ink over a pink official stamp. The stamp contains Mongolian text and a central emblem, likely the coat of arms of Mongolia. The signature is written in a cursive style.

П.ПҮРЭВЛХАГВА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1.1.2	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	75,139,740.18	5,089,720.58
1.1.3	Дансны авлага	169,782,603.97	167,622,603.97
1.1.4	Бараа материал	123,986,421.07	66,814,587.07
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	368,908,765.22	239,526,911.62
1.2.1	Үндсэн хөрөнгө	571,531,457.78	740,034,866.57
1.2.2	Биет бус хөрөнгө		3,000,000.00
1.2.3	Биологийн хөрөнгө	239,110.02	239,110.02
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	571,770,567.80	743,273,976.59
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	940,679,333.02	982,800,888.21
2.1.1.1	Дансны өглөг	184,730,854.66	224,839,004.66
2.1.1.3	Татварын өр	347,059,405.03	485,294,294.01
2.1.1.4	НДШ – ийн өглөг	47,507,620.46	53,876,754.80
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	3,107,923.55	6,897,203.10
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	582,405,803.70	770,907,256.57
2.1.2	Бусад урт хугацаат өр төлбөр	626,893,956.00	626,893,956.00
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	626,893,956.00	626,893,956.00
2.2	Өр төлбөрийн нийт дүн	1,209,299,759.70	1,397,801,212.57
2.3.1	Өмч:- төрийн	629,227,688.87	629,227,688.87
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	255,903,164.14	437,955,179.26
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(1,153,751,279.69)	(1,482,183,192.49)
2.3.10	Өмнөх үеийн үр дүн		(328,431,912.80)
2.3.11	Тайлант оны үр дүн	(1,153,751,279.69)	(1,153,751,279.69)
2.3.12	Эздийн өмчийн дүн	268,620,426.68	415,000,324.36
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	940,679,333.02	982,800,888.21

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	1,481,570,978.98	2,058,614,193.70
2	Борлуулалтын өртөг	1,775,759,967.24	2,140,272,730.36
3	Нийт ашиг(алдагдал)	(294,188,988.26)	(81,658,536.66)
4	Бусад орлого	12,729,764.55	1,316,660.73
8	Орлогын дүн	12,729,764.55	1,316,660.73
9	Борлуулалт, маркетингийн зардал	-	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	229,018,110.58	248,090,036.87
12	Зардлын дүн	229,018,110.58	229,018,110.58
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(510,477,334.29)	(328,090,036.87)
19	Орлогын татварын зардал	-	-
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(510,477,334.29)	(328,090,036.87)
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(510,477,334.29)	(328,090,036.87)

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

№	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	629,227,688.87	255,903,164.14	(1,153,751,279.69)	(268,620,426.68)
2	Нягтлан бодох бүртгэлийн өөрчлөлтийн алдааны залруулга				
3	Залруулсан үлдэгдэл	629,227,688.87	255,903,164.14	(1,153,751,279.69)	(268,620,426.68)
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			(328,431,912.80)	(328,431,912.80)
5	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		182,052,015.12		182,052,015.12
6	2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	629,227,688.87	437,955,179.26	(1,482,183,192.49)	(415,000,324.36)

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,892,579,623.31	2,199,042,540.23
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,873,928,491.00	2,192,179,125.00
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	3,933,765.00	221,536.00
	Бусад мөнгөн орлого	14,717,367.31	6,641,879.23
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,819,255,039.29	2,241,413,459.83
	Ажиллагчдад төлсөн	468,455,827.59	512,835,024.79
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	90,063,000.00	140,198,621.96
	Бараа материал худалдан авахад төлсөн	766,689,964.00	916,586,022.22
	Ашиглалтын зардалд төлсөн,	13,095,740.89	16,415,010.93
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	351,383,720.00	518,108,153.00
	Татварын байгууллагад төлсөн	41,712,065.52	5,509,921.42
	Даатгалын төлбөрт төлсөн	2,873,895.00	1,847,753.00
	Бусад мөнгөн зарлага	84,980,826.29	129,912,952.51
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	73,321,584.02	(42,370,919.60)
2.1	Мөнгөн орлогын дүн (+)		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)		27,679,100.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		24,379,100.00
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		3,300,000.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		(27,679,100.00)
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	73,321,584.02	(70,050,019.60)
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,815,156.16	75,139,740.18
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	75,139,740.18	5,089,720.58

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Д/д	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2024 оны Батлагдсан төлөвлөгөө	2024 оны 12 сарын гүйцэтгэл	Гүйцэтгэлийн хувь
	Бүтээгдэхүүн үйлдвэрлэл				
1	Үүнээс: Улсын чанартай АЗЗА	төг	1,363,000,000.0	1,763,166,731.0	129%
	Орон нутгийн чанартай АЗЗА	төг	850,000,000.0	295,447,462.7	35%
	Бусад орлого	төг		1,316,660.73	
	Нийт орлого	төг	2,213,000,000.0	2,059,930,854.4	93%
2	Нийт зардал	төг	,212,647,400.0	2,388,362,767.2	108%
	Үүнээс: Удирдлагын зардал	төг	282,206,100.00	248,090,036.87	51%
3	Татварын өмнөх ашиг	төг	352,600.0	(328,431,912.80)	-93146%
4	Цэвэр ашиг/алдагдал	төг	317,300.0	(328,431,912.80)	-103508%
5	Төсвийн төлбөр, шимтгэл	төг	503,565,600.0	145,708,543.38	29%
	а. Орлогын татвар	төг	35.3		0%
	б. НӨАТ	төг	174,800,000.0	3,000,000.0	2%
	в. НДШ	төг	258,251,700.0	140,198,622.0	54%
	г. Хүн амын орлогын татвар	төг	64,300.0		0%
	д. Үл хөдлөх хөрөнгө	төг	2,247,900.0	1,063,121.00	47%
	ё. АТБӨЯХАТ татвар	төг	1,351,500.0	1,446,800.4	107%
ж. Бусад татвар	төг	1,245.0		0%	
6	Төрийн өмчийн ногдол ашиг	төг	500.0		0%
7	Нийт ажиллагсдын тоо	төг	43	36	84%
8	Цалингийн сан	төг	45,977,000.0	643,027,363.72	68%
	1 ажилтны дундаж цалин	төг	1,833,300.0	1,488,489.3	81%
9	Борлуулалтын орлогын 1 төгрөгт оногдох зардал	төг	1.00		0%
10	Хөрөнгө оруулалт	төг	88,247,500.0	27,679,100.0	31%
11	Нийт авлага	төг	173,000,000.0	167,622,603.97	97%
12	Нийт өглөг	төг	748,393,900.0	1,397,801,212.57	187%
	Үүнээс: Богино хугацаат өглөг	төг	121,500,000.00	770,907,256.57	634%
	Урт хугацаат өглөг	төг	626,893,900.0	626,893,956.0	100%

Хүснэгт 2. "Орхон АЗЗА" ТӨХК-ийн 2024 оны орлого, зардлын гүйцэтгэлийн үзүүлэлт

/мянган төгрөг/

№	Зардлын төрөл	Өмнөх оны гүйцэтгэл	2024 оны дүн		Зөрүү	
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Өмнөх оноос	Төлөвлөснөөс
1	Үндсэн ба нэмэгдэл цалин	137,955.4	282,010.1	191,935.2	54,279.8	90,074.9
2	НДШ	21,245.1	35,713.1	23,325.9	2,080.8	12,387.2
3	ҮХЭХ-ын шимтгэл	12,144.1	24,550.0	665.0	(11,479.1)	23,885.0
4	Албан томилолт	3,450.0	6,816.0	1,761.0	(1,689.0)	5,055.0
5	Унаа, сэлбэг хэрэгсэл, шатахуун тос	16,750.0	20,420.0	9,954.7	(6,795.3)	10,465.3
6	Цахилгаан дулааны зардал	12,560.0	11,400.0	1,383.0	(11,177.0)	10,017.0
7	Бичиг хэрэг, аудитын зардал	4,500.0	5,100.0	55.0	(4,445.0)	5,045.0
8	Харилцаа холбооны зардал	3,120.0	5,820.0	886.9	(2,233.1)	4,933.1
9	ТУЗ-ын зардал	35,692.3	37,917.0	10,373.3	(25,319.0)	27,543.7
10	Өмгөөллийн зардал	1,500.0	3,500.0		(1,500.0)	3,500.80
11	Сургалтын зардал	2,500.0	3,500.0	2,230.0	(270.0)	1,270.0
12	Ахмадын сан	15,500.0	41,960.0	5,520.0	(9,980.0)	36,440.0

13	Хөдөлмөр хамгааллын зардал	700.0	3,500.0		(700.0)	3,500.0
Удирдлагын зардал		267,624.9	482,206.1	248,090.0	(19,534.9)	234,116.1
1	Түүхий эд материал, бусад материал	390,735.5	415,100.0	971,302.2	580,566.7	(556,202.2)
2	Түлш, шатахуун	291,835.1	338,100.0	316,420.0	24,584.9	21,680.0
3	Сэлбэг, хэрэгсэл	52,766.9	75,000.0	152,260.4	99,493.5	(77,260.4)
4	Цахилгаан эрчим хүч, дулаан	8,568.0	8,450.0	6,542.0	(2,026.0)	1,908.0
5	Үндсэн хөрөнгийн элэгдэл	56,089.9	69,380.0	41,732.2	(14,357.7)	27,647.8
6	Цалин	392,963.5	663,967.0	451,091.1	58,127.6	212,875.9
7	НДШ	55,876.5	84,083.2	140,708.5	84,832.0	(56,625.3)
8	Хөдөлмөр хамгаалал	14,500.0	33,911.0	22,871.3	8,371.3	11,039.7
9	Томилолт, хээрийн нэмэгдэл	15,840.0	20,150.2	18,645.0	2,805.0	1,505.2
10	Ажилтанд олгох нэг удаагийн тэтгэмж	4,500.0	5,800.0	4,500.0	0.0	1,300.0
11	Түлээ нүүрсний хөнгөлөлт	9,600.0	9,000.0	9,200.0	(400.0)	(200.0)
12	Бусад	7,150.0	7,500.0	5,000.0	(2,150.0)	2,500.0
Үйлдвэрлэлийн зардал		1,300,425.4	1,730,441.3	2,140,272.7	839,847.3	(409,831.4)
НИЙТ ЗАРДАЛ		1,568,050.3	2,212,647.4	2,388,362.8	820,312.5	175,715.4
1	Улсын чанартай АЗЗА	1,122,271.6	1,363,000.0	1,763,166.7	640,895.1	400,166.7
2	Орон нутгийн чанартай АЗЗА	445,928.3	850,000.0	295,447.5	(150,480.8)	(554,552.5)
3	Бусад орлого			1,316.7	1,316.7	1,316.7
НИЙТ ОРЛОГО		1,568,199.9	2,213,000.0	2,059,930.9	491,731.0	(153,069.1)
Нийт ашиг/алдагдал		(149,000.0)	352.6	(328,431.9)	(328,581.5)	22,646.3
1	Хойшлогдсон татварын зардал	0.0	0.0	0.0	0.0	0.0
2	Орлогын албан татвар	0.0	35.3	0.0	0.0	0.0
Татварын дараах ашиг/алдагдал		(149,000.0)	317.3	(328,431.9)	(328,581.5)	22,646.3

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 3,000.0 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 3,000.0 мянган төгрөгийн алдааг залруулж тайлагналаа.

Залруулсан алдаа:

- Тайлант хугацаанд 3,000.0 мянган төгрөгийн санхүүгийн программ авсан ажил гүйлгээг зардлаар бүртгэсэн байсныг залруулан, биет бус хөрөнгөөр бүртгэж тайлагнуулсан.

Аудитаар нийт 115,999.0 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 3,011.9 мянган төгрөгийн зөрчилд 4 төлбөрийн акт, 112,987.1 мянган төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага, 3 зөвлөмж хүргүүлсэн.

Төлбөрийн акт

Тайлант хугацаанд ажил үүргийн хуваарьт багтаагүй ажил гүйцэтгүүлж 817.7 мянган төгрөгийн цалин илүү олгосон, албан хаагчдад 258.0 мянган төгрөгийн хоол унааны нэмэгдлийг томилолтын зардалтай давхардуулан олгосон, шатахуун зарцуулах нормативаар шатахууны тооцоог бодоогүй 316.2 мянган төгрөг илүү зарцуулсан, үндэслэлгүйгээр 1,620.0 мянган төгрөгийг түлээ нүүрсний хөнгөлөлтийг орон сууцанд амьдардаг ажиллагсдад олгосон 4 зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Албан шаардлага

Тайлант онд ерөнхий инженерийг туршлага судлуулах чиглэлээр 9,796.5 мянган төгрөгийн томилолтын зардал гаргасан, хээрийн нэмэгдэл хөлснөөс тооцох 3,438.0 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг нийгмийн даатгалын тайланд тайлагнаагүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу байхад 66,874.0 төгрөгийн гүйлгээ хийсэн, улсын бүртгэлийн гэрчилгээнд заасан үйл ажиллагааны чиглэл хамаарахгүй аж ахуйн нэгжээс 11,000.0 мянган төгрөгийн ажил үйлчилгээ авсан, албан томилолтын хуудас, анхан шатны нотлох баримтгүй хангалтгүй, удирдамж, томилолтын тайлангүй 21,878.5 төгрөг зарцуулсан зэрэг 4 зөрчилд албан шаардлага хүргүүлэв.

Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Баримтын анхан шатны бүрдэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Албан хаагчдын цалинг 5, 9, 11-р саруудад сард нэг удаа, тогтсон өдөр олгоогүй байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 104.1-д "Цалин хөлсийг сард хоёроос доошгүй удаа тогтсон өдөр олгох бөгөөд олгох өдрийг хөдөлмөрийн дотоод хэм хэмжээ, эсхүл хөдөлмөрийн гэрээнд тусгана.", Хөдөлмөрийн дотоод журмын 8.1.3-д "Ажилтны цалин хөлсийг сар бүрийн 10, 25-ны өдрөөр тасалбар болгон 2 хуваан олгоно. Тухайн өдөр нь амралтын өдөр таарсан тохиолдолд тухайн долоо хоногийн баасан гаригт цалинг олгоно. Хэрэв тухайн өдөр нь нийтээр амрах баярын өдөр таарсан тохиолдолд аль тохиромжтой өдөр цалинг олгоно." гэж заасныг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:

Албан хаагчдын цалинг сард хоёроос доошгүй удаа, тогтсон өдөр олгож байх.

2. Урт хугацаат өглөгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Зам тээвэр, барилга хот байгуулалтын сайдын 2009 оны 166 дугаар тушаал, Төрийн өмчийн хорооны 2009 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 3/1538 дугаартай албан бичгийн дагуу 16 нэр төрлийн 590,615.3 мянган төгрөгийн машин механизмыг НББОУС-ын дагуу данс бүртгэлд тусгаагүй байна.

Энэ нь Монгол улсын засгийн газрын 2009 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн 284 дүгээр тогтоол "Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой зарим хуулийн этгээдийн талаар авах арга хэмжээний тухай" 6-т "дэлхийн банк болон Азийн хөгжлийн банкны урт хугацааны зээлийн санхүүжилтээр зам засвар, арчлалтын компаниудад хэрэгжүүлсэн тээвэр хөгжүүлэх төслийн үр дүнд бий болсон хөрөнгийн хэмжээгээр компаниудын дүрмийн санг нэмэгдүүлэх асуудлыг 2009 онд багтаан зохих журмын дагуу шийдвэрлэх" гэж заасныг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:

Балансын бусад урт хугацаат өр төлбөр, өглөгийн хэмжээгээр компанийн дүрмийн санг нэмэгдүүлэх.

3. Шилэн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Шилэн дансанд байршуулах мэдээллээс 2 мэдээллийг хуулийн хугацаа хоцроож, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 18,744.9 мянган төгрөгийн 4 шийдвэрийг мэдээлээгүй байна.

Энэ нь Төрийн өмчит компанийн тухай хуулийн 54.1-д "Төрийн болон орон нутгийн өмчит компани нь Шилэн дансны тухай хуулийн 6.1, 6.4, 6.8-д заасан болон Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдээллээс гадна дараах мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлэх үүрэгтэй:", Шилэн дансны тухай хуулийн 4.1-д "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална:", 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;", 6.4-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.8-д "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансанд байршуулах мэдээллийг хуулийн хугацаанд, иж бүрэн мэдээлж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Орхон АЗЗА	1	3.0			1	3.0	1	3.0				
Дүн	1	3.0			1	3.0	1	3.0				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Орхон АЗЗА	10	115.9	4	3.0	4	112.9	2	590.6				
Дүн	10	115.9	4	3.0	4	112.9	2	590.6				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Орхон АЗЗА	1	0						
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	11	115.9	4	3.0	4	112.9	3	590.6

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс тагталсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ								
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ	1	1				1		
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1				1		